

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говь-Алтай аймгийн Зоонозын өвчин судлалын төвийн 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ГАА-2024/05/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Алтай хот

2024 он

Дарга, тэргүүлэх аудитор: Г.Гүнжидмаа

Утас: 99998431 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг

Утас: 99175677 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn

Ахлах аудитор: Н.Гэрэлмаа

Утас: 99782918 Цахим хаяг: gerelmaan@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

1402, Хөгжил хороолол, Жинст баг,
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82099
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2024.02.25 № 89

танай _____ -ны № _____ -т

Сөрөг дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Говь-Алтай аймгийн Зоонозын өвчин судлалын төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь санхүүгийн тайланд материаллагаар нөлөөлсөн бөгөөд өргөн тархсаныг хангалттай, зохистой аудитын нотолгоонд үндэслэн Говь-Алтай аймгийн Зоонозын өвчин судлалын төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулаагүй гэж үзсэн.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар сахилгын шийтгэлтэй ажилтанд үр дүнгийн урамшуулал олгосон, Төрийн хэмнэлтийн тухай хууль зөрчин хот дотор автомашин ашиглан шатахуун зарцуулсан, ажилтнуудад шагнал, урамшуулал олгосон, ажлаас чөлөөлөгдсөн албан хаагчидтай ээлжийн амралтын дуусгалтын тооцоог хийгээгүй, зардлын эдийн засгийн ангилал зөрчиж гүйлгээ хийсэн, ажилчдын гарт олгосон цалинг зөрүүтэй тайлагнасан байна.

Жилийн эцсийн хөрөнгийн тооллогыг холбогдох хууль тогтоомжийн дагуу хийгээгүй, санхүүгийн тайланд өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, тусгаагүй, үнэ төлбөргүй орлогыг зөрүүтэй бүртгэсэн, шилэн дансны сайтад мэдээллийг бүрэн байршуулаагүй, төсвөөс цалингийн нөхөн олговор олгосон боловч буруутай этгээдээс нэхэмжлээгүй, Төрийн аудитын байгууллагын шийдвэрийг хэрэгжүүлээгүй зэрэг 864,787.1 мянган төгрөгийн зөрчил илэрсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 14 дүгээр зүйлийн 14.4, 16 дугаар зүйлийн 16.5.4, 16.5.5, 22 дугаар зүйлийн 22.1, 24 дүгээр зүйлийн 24.4, 29 дүгээр зүйлийн 29.4, 41 дүгээр зүйлийн 41.12.2, Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1,

0702900311

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1, 12 дугаар зүйлийн 12.1, 13 дугаар үйлийн 13.7, 20 дугаар зүйлийн 20.2.3, Хөдөлмөрийн тухай хуулийн 119 дүгээр зүйлийн 119.1 дэхь заалттай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, тасалбар болголт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Тус төв нь 2023 онд тарваган тахлын, галзуугийн өвчлөлийн дуудлагад ажиллаж хариу арга хэмжээг авч хэрэгжүүлэн ажилласан ба тарваган тахал, хачигт халдвар, боом, шувууны томуу зэрэг өвчний гүнзгийрэл болон тандалт судалгаа шинжилгээг хийж ажилласан байна.

Аудитын гол асуудал

Тайлант онд тус байгууллагын дарга 2 удаа, нягтлан бодогч, нярав тус бүр 4 удаа өөрчлөгдсөн байна.

Бусад асуудлын хэсэг

Тайлант онд төсвийн захирагчийн 4 зорилтын хүрээнд 69 арга хэмжээг хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаснаас 64 арга хэмжээ бүрэн, 5 арга хэмжээг 65.0 хувь буюу нийт дүнгээр 90.7 хувиар биелүүлж, биелэлтийг Зоонозын өвчин судлалын үндэсний төв, Эрүүл мэндийн газарт хүргүүлсэн боловч дээд байгууллагаас ажлыг дүгнээгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага


Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Г.ГҮНЖИДМАА



Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

/мян.төгрөгөөр/

Үзүүлэлт	2022.12.31	2023.12.31
Санхүүгийн байдлын тайлан		
Эргэлтийн хөрөнгийн дүн	154,299.1	223,750.3
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	274,527.2	387,070.5
Нийт хөрөнгийн дүн	428,826.3	610,820.8
Нийт өр төлбөрийн дүн	-	2,003.0
Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	428,826.3	608,817.8
Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	428,826.3	610,820.8
Үйл ажиллагааны орлогын дүн	597,183.3	735,504.5
Үйл ажиллагааны зардлын дүн	491,741.4	555,513.1
Үйл ажиллагааны үр дүн	105,441.9	179,991.4
Үйл ажиллагааны бус үр дүн	0.0	0.0
Үйл ажиллагааны нийт үр дүн	102,840.5	179,991.4
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	340,544.8	428,826.3
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	325,985.8	428,826.3
Тайлант оны үр дүн	102,840.5	179,991.4
Эцсийн үлдэгдэл	428,826.3	608,817.8
Мөнгөн гүйлгээний тайлан		
Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	437,114.9	519,550.2
Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	432,074.9	519,550.2
Үйл ажиллагааны ЦМГ	5,040.0	-
Хөрөнгө оруулалтын ЦМГ	(5,040.0)	-
Санхүүгийн ажиллагааны ЦМГ		
Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	0.0	0.0
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0	0.0
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.0	0.0
Төсвийн гүйцэтгэлийн тайлан		
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	403,485.0	482,867.2
Урсгал зардал	403,485.0	482,867.2
Хөрөнгийн зардал	-	-
Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	403,485.0	482,867.2
Улсын төсвөөс санхүүжих	403,485.0	482,867.2
Орон нутгийн төсвөөс санхүүжих	-	-
	-	-

Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитын илрүүлэлт

Аудитаар 26,592.3 мянган төгрөгийн бүртгэл тайлагналын алдаа¹-г аудитын явцад залруулж, баталгаажуулав.

Залруулсан алдаа

- **Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой:** Санхүүгийн байдлын тайланд мөнгөн хөрөнгийг төрийн сангийн харилцах дансны үлдэгдлээр,
- Бараа материалыг 478.0 мянган төгрөгөөр илүү,

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

- Үндсэн хөрөнгийг данс хооронд зөрүүлэн бүртгэж 464.7 мянган төгрөгийн зөрүү үүсгэсэн,
- Өр төлбөрийг 1,480.4 мянган төгрөгөөр илүү бүртгэсэн зэрэг нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;" заалтыг зөрчсөн байна.

Аудитаар нийт 864,787.1 мянган төгрөгийн 13 зөрчил² илэрснээс, 1,814.7 мянган төгрөгийн 3 төлбөрийн акт тогтоож, 862,972.4 мянган төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх талаар 10 албан шаардлага өгсөн.

5.1 Төлбөрийн акт

1. Төрийн хэмнэлтийн тухай хууль зөрчин хот дотор автомашин ашиглаж 487.8 мянган төгрөгийн, албаны бус хэрэгцээнд 138.9 мянган төгрөгийн шатахууныг тус тус зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-т "Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын тэргүүн дэд, дэд, орлогч дарга болон дэд сайд, яамны төрийн нарийн бичгийн дарга, Засгийн газрын агентлагийн дарга, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн захирал, төсвийн байгууллагын дарга хот дотор албан тушаалын суудлын автомашин ашиглахыг хориглоно", 6.2-т "Аймаг, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг даргаас бусад этгээд албан тушаалын суудлын автомашин ашиглахыг хориглоно" гэж заасантай нийцэхгүй, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албаны бус хэрэгцээнд зарцуулсан шатахууны мөнгийг төсвийн орлого болгох төлбөрийн акт тогтоосон.

2. Сахилгын шийтгэлтэй ажилтанд улирлын үр дүнгийн урамшуулал 462.1 мянган төгрөгийг олгосон нь Хөдөлмөрийн тухай хуулийн 123 дугаар зүйлийн 123.8-т "Хөдөлмөрийн сахилгын шийтгэл ногдуулснаас хойш нэг жил өнгөрвөл ажилтныг хөдөлмөрийн сахилгын шийтгэлгүйд тооцно", Төрийн албаны тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.7-т "Төрийн жинхэнэ албан хаагч сахилгын шийтгэл ногдуулсан өдрөөс хойш 1 жилийн дотор сахилгын шийтгэл хүлээгээгүй бол түүнийг сахилгын шийтгэлгүйд тооцно", Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтын 2 дугаар зүйлийн 2.7-т "Хууль тогтоомжийн дагуу сахилгын шийтгэл хүлээсэн төрийн албан хаагчийн сахилгын шийтгэлгүйд тооцогдох хугацаа дуусаагүй бол тухайн төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгохгүй" гэж заасантай нийцэхгүй, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Сахилгын шийтгэлтэй албан тушаалтанд олгосон урамшууллыг төсвийн орлого болгох төлбөрийн акт тогтоосон.

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

3. Төрийн хэмнэлтийн тухай хууль зөрчин цалингийн зардлаас ажилчдын дунд спортын тэмцээн зохион байгуулж 725.8 мянган төгрөгийн ур чадварын нэмэгдэл, шагнал олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1-т "Төрийн албан хаагчид хууль болон албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргээ хэрэгжүүлсний төлөө төрөөс цалин хөлс олгоно." гэж заасантай нийцэхгүй, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон шагналыг төсвийн орлого болгох төлбөрийн акт тогтоосон.

5.2 Албан шаардлага


1. Ажилчдын гарт олгосон цалин харилцахаас шилжүүлсэн цалингаас 3,059.6 мянган төгрөгөөр зөрүүтэй байгаа нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1-т "Төрийн албан хаагчид хууль болон албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргээ хэрэгжүүлсний төлөө төрөөс цалин хөлс олгоно." гэж заасантай нийцэхгүй, иж бүрэн байх, оршин байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Ажилчдын цалин, хөдөлмөрийн хөлсийг үнэн зөв тайлагнан тооцоо нийлж, арга хэмжээг авч ажиллах албан шаардлага хүргүүлсэн.

2. Зардлын эдийн засгийн ангилал зөрчиж урсгал засварын зардлаас 500.0 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэсэн байгаа нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" 22 дугаар зүйлийн 22.1-т "Төсвийг тогтоосон ангиллын дагуу төлөвлөж, гүйцэтгэлийг хэрэгжүүлж, бүртгэн, тайлагнана", "Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалын хавсралт "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар" Урсгал засварын зардал: Байгууллага өөрийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй барилга, байгууламж, тээврийн хэрэгсэлд урсгал шинжтэй засвар хийх зориулалтаар бэлтгэсэн материал, сэлбэг, засвар, үйлчилгээний ажлын хөлс энд хамаарна." гэсэн заалттай нийцэхгүй, ангилал, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг батлагдсан эдийн засгийн ангиллын дагуу зарцуулах албан шаардлага хүргүүлсэн.

3. Ажлаас чөлөөлөгдсөн 5 ажилтанд амралтын цалингийн дуусгалтын тооцоо хийгээгүй нь Хөдөлмөрийн тухай хуулийн 83 дугаар зүйлийг 83.1-т "Ажил олгогч ажилтны ажлын байрыг хэвээр хадгалах тохиолдолд ажлыг нь түр, хөдөлмөр эрхлэлтийн харилцаа дуусгавар болсон тохиолдолд бүрмөсөн хүлээн авна", 110 дугаар зүйлийн 110.3-т "Хөдөлмөр эрхлэлтийн харилцаа нь дуусгавар болж байгаа ажилтанд ажилласан хугацаанд ногдох ээлжийн амралтын тооцоо хийж, цалинг олгоно", Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн А/191 дүгээр тушаалын хавсралт "Ээлжийн амралт олгох, ээлжийн амралтын цалин тооцох журам"-ын 2.8-т "Ажилтны хөдөлмөр эрхлэлтийн харилцааг цуцлах, дуусгавар болгох үед ажил олгогч нь ажилтантай ээлжийн амралтын тооцоог дараах байдлаар хийнэ. Үүнд: ажилтанд ажилласан хугацаанд нь ногдох ээлжийн



амралтын цалинг олгох; ажилтнаас илүү олгосон ээлжийн амралтын цалингийн суутгалыг хийх" гэсэн заалттай нийцэхгүй, ангилал, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Ажлаас чөлөөлөгдсөн ажилтантай ээлжийн амралтын цалингийн дуусгалын тооцоог хууль журмын дагуу хийх албан шаардлага хүргүүлсэн.

4. Шүүхийн шийдвэрээр ажилгүй байсан хугацааны нөхөн төлбөр болох 30,473.5 мянган төгрөгийг төсвөөс төлсөн боловч буруутай этгээдээр нөхөн төлүүлээгүй нь Захиргааны ерөнхий хуулийн 103.1-т "Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлнэ.", Төрийн албаны тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.1-т "Иргэнийг, эсхүл улс төрийн албан хаагчаас бусад төрийн албан хаагчийг төрийн албанд хууль бусаар томилсон, чөлөөлсөн, түр чөлөөлсөн, халсныг төрийн албаны төв байгууллага, эсхүл шүүх тогтоосон бол төрд учруулсан хохирлыг уг шийдвэрийг гаргасан буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлнэ" гэсэн заалттай нийцэхгүй, ангилал, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Цалингийн нөхөн олговрыг буруутай этгээдээс нэхэмжлэн төсвийг хохиролгүй болгох арга хэмжээг авч ажиллах албан шаардлага хүргүүлсэн.

5. Албан томилолтын баталсан удирдамж, хөтөлбөргүй албан томилолтоор ажиллаж 2,023.5 мянган төгрөгийн албан томилолтын зардал олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоолын хавсралтын 2 дугаар зүйлийн 2.1-т "Төрийн албан хаагчийг гадаад улсад болон нэг аймаг, хотоос нөгөө аймаг, хотод, түүнчлэн аймаг, хотын дотор өглөө ажилд очих, орой буцах боломжгүй газарт тухайн байгууллага болон дээд шатны удирдах байгууллагаас баталсан удирдамж, төлөвлөгөө, шийдвэрийн дагуу тодорхой хугацаагаар томилон ажиллуулсан нөхцөлд албан томилолтоор ажиллах үеийн нөхөх төлбөр олгоно" гэсэн заалттай нийцэхгүй, ангилал, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Томилолтын анхан шатны баримтад үндэслэн зөвшөөрлийн дагуу нөхөн төлбөрийг олгож байх албан шаардлага хүргүүлсэн.

6. Санхүүгийн тайланд 2,003.0 мянган төгрөгийн өглөгийг тусгасан боловч тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;", 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.5-т "хуваарьт болон хугацаа хэтэрсэн өр төлбөрийг жилийн төсөвтөө бүрэн тусгаж өр төлбөр барагдуулах төлөвлөгөө,



хуваарь баталж хэрэгжүүлэх" гэсэн заалттай нийцэхгүй, ангилал, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Харилцагч байгууллагатай өр төлбөрийн тооцоо нийлж бүртгэлд үнэн тусгах албан шаардлага хүргүүлсэн.

7. Шатахууны зарцуулалт тодорхой бус, жолоочийн замын хуудсанд тооцоо бодолгүйгээр 2,824.5 мянган төгрөгийн шатахууныг зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалттай нийцэхгүй, ангилал, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Жолоочийн тооцооны хуудсанд үндэслэн шатахууны тооцоог бодох албан шаардлага хүргүүлсэн.

8. Дотоод хяналт шалгалт хариуцсан ажилтнуудад ажлыг дүгнэн 589.5 мянган төгрөгийн урамшуулал олгосон боловч хяналт шалгалтын ажлын тайлангүй, санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн дотоод хяналт хангалтгүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалттай нийцэхгүй, ангилал, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Дотоод хяналтыг үр дүнтэй зохион байгуулах албан шаардлага хүргүүлсэн.

9. Хөрөнгийн тооллогыг данс бүрээр хийсэн тооллогын баримт, тооцоо бодсон актгүй 810,265.9 мянган төгрөгөөр, акталсан хөрөнгийн дүн 399.4 мянган төгрөгөөр, үнэ төлбөргүй худалдан авсан хөрөнгө 2,967.0 мянган төгрөгөөр тус тус зөрүүтэй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна.", 12.2-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ":, 12.2.1.жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө; 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.4-т "комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх" гэсэн заалттай нийцэхгүй, ангилал, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хөрөнгийн тооллогыг хуулийн дагуу хийн тооцоо бодож зөрүүг арилгах албан шаардлага хүргүүлсэн.

10. Бараа материалын үлдэгдлийн тайлангаар 2023 оны 12 дугаар сарын 07-ны байдлаар шатахууны үлдэгдлийг 8,246.9 мянган төгрөг гэж тайлагнасан боловч няравт ажил



хүлээлцсэн актаар 380.0 мянган төгрөгийн талоныг хүлээлгэн өгсөн нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалттай нийцэхгүй, ангилал, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Бараа материалын тооллого зохион байгуулж дутагдсан хөрөнгийг хууль эрх зүйн хүрээнд шийдвэрлэх албан шаардлага хүргүүлсэн.

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/ сая төгрөгөөр/												
Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусан илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Зоонозын өвчин судлалын төв	4	26.6	-	-	4	26.6	4	26.6	-	-	-	-
Дүн	4	26.6	-	-	4	26.6	4	26.6	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Байгууллагын нэр	Нийт зөрчил		/сая төгрөгөөр/ Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн										
Зоонозын өвчин судлалын төв	13	864.8	3	1.8	10	863.0	-	-	-	-	-	-
Дүн	13	864.8	3	1.8	10	863.0	-	-	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/								
Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
өвчин судлалын төв	1	-	-	-	1	-	-	-
-Дүн	-1	-	-	-	1	-	-	-
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Зоонозын өвчин судлалын төв	1	0.7	-	-	1	0.7	-	-
Дүн	1	0.7	-	-	1	0.7	-	-
Нийт дүн	2	0.7	-	-	2	0.7	-	-

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ		1					1	
	НИЙТ		1					1	